



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 20 өдөр

Дугаар

A/117

Улаан-Уул

Шүлхий өвчнөөс урьдчилсан
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дах заалт, Улсын Онцгой комиссын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоол, "Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалты ажлыг зохион байгуулах тухай" Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2022 оны А/191 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/585 дугаар захирамж, сумын Онцгой комиссын 2022 оны 09 сарын 20-ний өдрийн 07 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 20-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 08-ны дотор зохион байгуулсугай.

2.Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Дархлаажуулалтын ажлыг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, багийн нутаг дэвсгэрт байгаа үхэр сүргийг бүрэн хамруулах, шаардлагатай хашаа, хороо, хүн хүчээр хангах, зар мэдээг түргэн шуурхай хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт, хариуцсан багийн малд дархлаажуулалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжийн эмч нарт тус тус үүрэг болгосугай.

4.Вакцины дархлаа тогтох 28 хоногийн хугацаанд малын шилжилт хөдөлгөөн хийхийг хориглож, малчдын нүүдэл, малын хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (М.Зоригт)-д даалгасугай.

5. Дархлаажуулалтын ажилд шаардагдах зардал 1,450,500 (Нэг сая дөрвөн зуун тавин мянга таван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган

642201237